



2026 ОНД ЭРСДЭЛИЙГ СААРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БУЮУ
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны 01 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

Д/д	Тодорхойлсон эрсдэл	Эрсдэлийн ангилал	Хариу арга хэмжээний санал (Тайлбар)	Хариуцах нэгж	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа
1	Хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал хүрэлцэхгүй байх, санхүүгийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх	3	Нэг. Хэрэгцээ шаардлага буюу төсөв санхүүгийн чиглэлээр Төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан 2026 оны төсвийн төслийг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад уламжлан Сангийн яаманд хүргүүлэх; Батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах санал, тайлбарын хамт Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэн шийдвэрлүүлэх; Дотоод аудит, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах	Санхүү, хангалт үйлчилгээний газар, Хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүд	6 сар, 12 сар
Хоёр. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын чиглэлээр					
2.	Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг харьяатаас гарахыг шаардах, аль нэг улсынхаа иргэний харьяаллаа сонгохыг тулгах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс хоёрдмол харьяалалтай иргэд нэмэгдэх	A1	Хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулах, шалгалтаар илэрсэн хоёрдмол харьяалалтай Монгол Улсын иргэдийн мэдээллийг нэгдсэн санд бүрэн гүйцэд оруулах; Хүний эрхийг дээдлэн, эрх зүйн зохицуулалтыг тодорхой ойлгомжтой болгох талаар холбогдох дээд шатны байгууллагад хүсэлт хүргүүлэх	Иргэний харьяаллын газар	6 сар, 12 сар

1	2	3	4	5	6
Гурав. Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын чиглэлээр					
3.	Алслагдсан хилийн боомтод ажиллаж, амьдрах орчин нөхцөл бүрэн хангагдаагүйгээс ажиллах тогтворгүй байдал үүсэх	Б1	Тогтвор сууршилтай ажиллах нөхцөл, боломжийг хангах талаар шат дараатай арга хэмжээ авах	Захиргаа, удирдлагын газар	6 сар, 12 сар
4.	Хадгаламжийн нэгжүүд цаасан баримтад байгаа тохиолдолд эрсдэл бий болсноор нөхөн сэргээгдэх боломжгүй тул цахим хэлбэрт шилжүүлэх, хортон шавж, мэрэгч амьтдаас урьдчилан сэргийлэх	Б2	Цаасан суурьтай байнга хадгалах баримтыг эрсдлээс хамгаалах зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх, хортон шавж, мэрэгчийн устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэх	Захиргаа, удирдлагын газар, Мэдээллийн технологийн хэлтэс	6 сар, 12 сар
Дөрөв. Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэлийн чиглэлээр					
5.	Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх	Г1	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар холбогдох байгууллагатай хамтран баталсан төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийн ажиллах, мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах	Төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүд	6 сар, 12 сар
6.	"Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" (ISF) системийн хэвийн ажиллагаа алдагдах, мэдээллийн сан устах, гэмтэх үед дахин сэргээгдэхгүй байхаас урьдчилан сэргийлэх	Г2	Хэрэглэгчийн системд хандах эрх, төхөөрөмжийг бүртгэлжүүлэх эрхийн тохиргоо хийх, Давхар ажиллагааны зарчмаар ажиллах сервер тохируулах	Захиргаа, удирдлагын газар, Виз, зөвшөөрлийн газар, Мэдээллийн технологийн хэлтэс	6 сар, 12 сар
7.	Цахилгаан эрчим хүч, ус дулааны доголдол, гадны нөлөөллөөс шалтгаалан бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан эвдрэх, сүлжээний техник хэрэгсэлд саатал учирч тасалдсанаар механик ажиллагаа явагдаж, үйл ажиллагааны ачаалал нэмэгдэж, мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдал алдагдах	Г3	Цахилгаан эрчим хүч, ус дулааны доголдол, гадны нөлөөллөөс болж үүсэх эрсдэлээс сэргийлэн нөөц аваарын төхөөрөмж, багаж хэрэгслийг бэлэн байлгах	Мэдээллийн технологийн хэлтэс Хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүд	6 сар, 12 сар

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТЭС**